

Хамгааллын журмын тухай мэдэгдэл Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хуулийн Б хэсэг болон Калифорнийн боловсролын тухай хууль тогтоомжид нийцүүлсэн эцэг эх, хүүхдийн тусгай боловсролын эрх

2022 оны 6-р сард шинэчилсэн хувилбар

Тайлбар: Энэхүү баримт бичигт ашигласан сургуулийн дүүрэг гэсэн нэр томъёо нь таны хүүхдийг тусгай боловсролын хөтөлбөрөөр хангах үүрэгтэй төрийн боловсролын байгууллагыг тодорхойлоход ашигласан болно. Үнэлгээ гэдэг нэр томъёо нь үнэлгээ, шалгалт гэсэн утгатай. Холбооны болон муж улсын хуулиудыг энэхүү мэдэгдлийн төгсгөлд англи хэлний товчлол ашиглан иш татсан болно.

Хамгааллын журмын тухай мэдэгдэл гэж юу вэ?

Энэхүү мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй 3-21 хүртэлх насны хүүхэд ба 18 нас хүрсэн сурагчдын эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон орлогч эцэг эхийн хувиар таныг сурч боловсрох эрх эсвэл хамгааллын журмын тухай ойлголтоор хангана.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хуулийн (IDEA) дагуу Хамгааллын журмын тухай мэдэгдэл шаардлагатай байдаг бөгөөд танд дараах тохиолдолд үүнийг өгөх ёстой:

- Та хуулбар авах хүсэлт гаргасан үед
- Таны хүүхдийг анх удаа тусгай боловсролын үнэлгээнд орохыг зөвлөсөн үед
- Танд хүүхдээ үнэлэх үнэлгээний төлөвлөгөө өгөх бүрт
- Хичээлийн жилд анх удаа төрийн болон зохих журмын дагуу гомдол хүлээн авсан бол, мөн
- Хуваарилалтыг өөрчлөх буюу хасалт хийх шийдвэр гаргасан үед

(АНУ-ын хууль тогтоомжийн [USC] 20-р зүйлийн 1415[d] хэсэг; Холбооны улсын хууль тогтоомжийн [CFR] 34-р зүйлийн 300.504 хэсэг; Калифорнийн боловсролын тухай хууль тогтоомжийн [EC] 56301[d] [2], EC 56321 болон EC 56341.1[g]] [1] хэсгүүд) IDEA гэж юу вэ?

IDEA нь сургуулийн дүүргүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд "Улсын зохих ёсны үнэ төлбөргүй боловсрол" (FAPE) олгохыг шаарддаг холбооны хууль юм.

Улсын зохих ёсны үнэ төлбөргүй боловсрол гэдэг нь таны хүүхдэд тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг ганцаарчилсан боловсролын хөтөлбөрт (IEP) заасны дагуу улсын хяналтан дор үнэ төлбөргүй үзүүлэхийг хэлнэ.

Би хүүхдийнхээ боловсролтой холбоотой шийдвэрт оролцож болох уу?

Танд хүүхдийнхээ тусгай боловсролын хөтөлбөртэй холбоотой аливаа шийдвэр гаргах хуралд оролцох боломжийг олгох ёстой. Таны хүүхдийн тодорхойлолт (шаардлага хангасан эсэх), үнэлгээ эсвэл боловсролын хуваарилалттай холбоотой IEP-ийн багийн хурлууд болон таны хүүхдийн FAPE-тай холбоотой бусад асуудлуудад оролцох эрхтэй. (*USC 20-р зүйлийн 1414[d] [1]B–[d][1][D] хэсэг; CFR 34-р зүйлийн 300.321 хэсэг; EC 56341[b] хэсэг болон EC 56343[c] хэсэг*)

Эцэг эх эсвэл асран хамгаалагч болон орон нутгийн боловсролын агентлаг (LEA) нь IEP-ийг хөгжүүлэлтэд оролцох, IEP-ийн багийн хурлын үйл явцыг цахим аудио хэлбэрээр бичлэг хийх санаачлагыг гаргах эрхтэй. Хурал болохоос доод тал нь 24 цагийн өмнө эцэг эх эсвэл асран хамгаалагч нь IEP-ийн багийн гишүүдэд хурлын бичлэг хийх хүсэлтэй байгаагаа мэдэгдэх ёстой. Хэрвээ эцэг, эх, асран хамгаалагч нь LEA-д IEP-ийн хурлын бичлэг хийхийг зөвшөөрөөгүй бол хурлыг дуу хураагуурт бичиж болохгүй.

Таны эрхэд FAPE-ын олдоцын талаарх мэдээлэл, хөтөлбөрийн бүх сонголтууд, улсын болон улсын биш боломжит бүх хувилбарын хөтөлбөрүүд багтана. (*USC 20-р зүйлийн 1401[3] ба 1412[a][3] хэсгүүд; CFR 34-р зүйлийн 300.111 хэсэг; EC 56301, 56341.1[g][1] ба 56506 хэсгүүд*)

Би хаанаас нэмэлт туслалцаа авч болох вэ?

Хэрэв та хүүхдийнхээ боловсролд санаа зовниж байгаа бол хүүхдийнхээ багш эсвэл захиргааны ажилтантай холбогдож хүүхдийнхээ тухай болон таны ажигласан аливаа асуудлын талаар ярилцах нь чухал. Танай сургуулийн дүүрэг эсвэл Тусгай боловсролын орон нутгийн төлөвлөлтийн бүсийн (SELPA) ажилтнууд таны хүүхдийн боловсрол, таны эрх болон хамгааллын журмын тухай асуултуудад хариулах боломжтой. Мөн танд санаа зовниж буй асуудал байгаа тохиолдолд энэхүү албан бус харилцан яриа нь ихэвчлэн асуудлыг шийдэж, нээлттэй харилцааг хадгалахад туслах болно.

Мөн та муж даяар байрлах Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүлийг чадавхижуулах төвүүд (FECs) эсвэл Эцэг эхийн сургалт болон мэдээллийн төвүүд (PTICs) зэрэг Калифорнийн эцэг эхчүүдийн байгууллагын аль нэгтэй нь холбогдох боломжтой. Эдгээр байгууллагууд нь боловсролын тогтолцоог сайжруулах, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөгжлийн

T21-822, Хамгааллын журмын тухай мэдэгдэл, Англи хэл, Arial фонт
Калифорнийн Боловсролын Газар
Хуудас 3/23

бэрхшээлтэй сурагчид болон залуучуудын гэр бүлийг мэдээлэл, сургалт, нэмэлт эх үүсвэрээр хангах зорилгоор байгуулагдсан. Эдгээр байгууллагуудын холбогдох мэдээллийг Калифорнийн боловсролын хэлтэс (CDE) Калифорнийн эцэг эхчүүдийн тусгай боловсролын байгууллагуудын <https://www.cde.ca.gov/sp/se/qa/caprntorg.asp> веб хуудаснаас авна уу.

Хамгааллын журмыг ойлгоход танд туслах нэмэлт эх сурвалжуудыг энэхүү баримт бичгийн төгсгөлд жагсаасан болно.

Хэрэв миний хүүхэд сонсголгүй, сонсголын бэрхшээлтэй, хараагүй, харааны бэрхшээлтэй эсвэл хараагүй-дүлий бол яах вэ?

Мужийн тусгай сургуулиуд нь сонсголгүй, сонсголын бэрхшээлтэй, хараагүй, харааны бэрхшээлтэй эсвэл хараагүй-дүлий сурагчдад зориулж өөрийн гурван байгууллагаар дамжуулан үйлчилгээ үзүүлдэг: Фремонт болон Риверсайдад байрлах Сонсголгүй хүүхдүүдийн Калифорнийн сургууль, Фремонтод байрлах Хараагүйхүүхдүүдийн Калифорнийн сургууль. Сонсголгүй хүүхдүүдийн улсын 2 сургууль нь балчир наснаас эхлээд 21 хүртэлх насны сурагчдад байрлан суралцах болон өдрийн сургалтын хөтөлбөрийн аль алиныг нь санал болгодог. Мөн яг ийм төрлийн хөтөлбөрийг 5-аас 21 насны сурагчдад Хараагүй хүүхдүүдийн Калифорнийн сургууль санал болгодог. Мужийн тусгай сургуулиуд нь мөн үнэлгээ хийх үйлчилгээ, техникийн туслалцаа үзүүлдэг. Мужийн тусгай сургуулиудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах бол CDE, Мужийн тусгай сургуулиудын <https://www.cde.ca.gov/sp/ss/index.asp> веб хуудсаар зочлох, эсвэл хүүхдийнхээ IEP багийн гишүүдээс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Мэдэгдэл, Зөвшөөрөл, Үнэлгээ, Орлогч эцэг -эхийн томилгоо болон сургалтын тайлан руу нэвтрэх эрх

Урьдчилсан бичгэн мэдэгдэл

Мэдэгдэл ямар үед хэрэгтэй вэ?

Сургуулийн дүүрэг таны тусгай хэрэгцээт хүүхдийн тодорхойлолт, үнэлгээ, боловсролын хуваарилалт зэрэгт өөрчлөлт оруулахыг санаачлах эсвэл FAPE-ээр хангах явдлыг санал болгох эсвэл татгалзах тохиолдолд энэхүү мэдэгдлийг өгөх ёстой. (USC 20-р зүйлийн 1415[b][3] ба (4) хэсэг, 1415[c][1] ба 1414[b][1] хэсэг; CFR 34-р зүйлийн 300.503 хэсэг; EC 56329 ба 56506[a] хэсгүүд)

Таныг үнэлгээ гаргуулах хүсэлтээ бичгээр гаргаж өгсөнөөс хойш сургуулийн дүүрэг таны хүүхдэд үнэлгээ хийх хүсэлтийн тухай бичгээр мэдэгдэл өгөх эсвэл үнэлгээний төлөвлөгөө хэлбэрээр 15 өдрийн дотор мэдээллэх ёстой. Мэдэгдэл нь танд ойлгомжтой байх ёстой бөгөөд хэрэв тийм боломжгүй бол таны төрөлх хэл дээр эсвэл харилцааны өөр хэлбэрээр байх ёстой. (*CFR* 34-р зүйлийн 300.304 хэсэг; *EC* 56321 хэсэг)

Мэдэгдэл надад юу хэлэх вэ?

Урьдчилсан бичгэн мэдэгдэл дараах зүйлсийг агуулсан байх ёстой:

1. Сургуулийн дүүргээс санал болгосон эсвэл татгалзсан талаарх тодорхойлолт
2. Яагаад санал болгосон эсвэл татгалзсан тухай тайлбар
3. Санал болгосон эсвэл татгалзсан үйл ажиллагааны суурь болгон ашигласан үнэлгээний журам, бүртгэл эсвэл агентлагийн бүртгэл
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх хамгааллын журмын дагуу хамгаалагдсан байдаг тухай мэдэгдэл
5. Энэ хэсгийн заалтыг ойлгох тал дээр туслалцаа авахын тулд эцэг эхчүүдийн хандаж болох эх сурвалжууд
6. IEP багийн харгалзан үзсэн бусад сонголтын тодорхойлолт болон тэдгээр сонголтуудаас татгалзсан шалтгаан; болон
7. Санал болгосон эсвэл татгалзсан арга хэмжээнд хамааралтай өөр бусад хүчин зүйлсийн тодорхойлолт. (*USC* 20-р зүйлийн 1415[b][3] ба [4], 1415[c][1], ба 1414[b][1] хэсгүүд; *CFR* 34-р зүйлийн 300.503 хэсэг)

Эцэг эхийн зөвшөөрөл

Үнэлгээ хийхэд миний зөвшөөрөл хэзээ шаардлагатай вэ?

Та хүүхдээ тусгай боловсролын үйлчилгээнд санал болгохөртэй. Таны хүүхдийн анхны тусгай боловсролын үнэлгээг хийхийн өмнө та мэдээлэлтэй танилцаж, бичгээр зөвшөөрөл өгөх ёстой. Санал болгосон үнэлгээний төлөвлөгөөг хүлээн авснаас хойш шийдвэр гаргахад эцэг эхэд доод тал нь 15 хоног байна. Зөвшөөрөл хүлээн авсан даруйд үнэлгээг эхлүүлж, танаас зөвшөөрөл ирсэнээс хойш 60 хоногийн дотор дуусгах бөгөөд IEP-ийг боловсруулах ёстой.

Үйлчилгээнд миний зөвшөөрөл хэзээ шаардлагатай вэ?

Танай сургуулийн дүүрэг таны хүүхдэд тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээнүүдийг үзүүлэхийн өмнө та мэдээлэлтэй танилцаж, бичгээр зөвшөөрөл өгөх ёстой.

Эцэг эх зөвшөөрөл өгөөгүй үед ямар журам баримтлах вэ?

Хэрэв та эхний үнэлгээг хийх зөвшөөрөл өгөөгүй эсвэл зөвшөөрөл өгөх хүсэлтэд хариу өгөөгүй бол сургуулийн дүүрэг зохих журмын дагуу эхний үнэлгээг явуулж болно.

Хэрэв та үйлчилгээ эхлүүлэхийг зөвшөөрөхөөс татгалзвал, сургуулийн дүүрэг тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээгээр хангах ёсгүй бөгөөд зохих журмын дагуу үйлчилгээ үзүүлэхээр эрэлхийлэхгүй.

Хэрэв та хүүхдэдээ зориулсан тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг бичгээр зөвшөөрсөн ч, IEP-ийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг зөвшөөрөхгүй бол таны зөвшөөрсөн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг нэн даруй хэрэгжүүлж эхлэх ёстой.

Хэрэв сургуулийн дүүрэг таныг тусгай боловсролын хөтөлбөрөөс санал болгосон бүрэлдэхүүн хэсгийг зөвшөөрөөгүй ба үүнийг таны хүүхдэд FAPE-ээс олгох шаардлагатай гэж үзвэл зохих журмын дагуу сонсголыг эхлүүлнэ. Хэрэв сонсголыг зохих журмын дагуу явуулсан бол сонсголын шийдвэр нь эцсийн бөгөөд заавал биелүүлэх ёстой байна.

Дахин үнэлгээ хийх тохиолдолд сургуулийн дүүрэг таны зөвшөөрлийг авахын тулд зохих арга хэмжээг баримтжуулж авах ёстой. Хэрэв та хариу өгөхгүй бол сургуулийн дүүрэг дахин үнэлгээг таны зөвшөөрөлгүй үргэлжлүүлэх боломжтой. (*USC 20-р зүйлийн 1414[a][1][D]* ба *1414[c]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.300* хэсэг; *EC 56506[e]*, *56321[c]* ба *[d]*, *56346* хэсгүүд).

Би зөвшөөрлийг хэзээ цуцалж болох вэ?

Хэрэв тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг анхлан үзүүлсний дараа хүүхдийн эцэг эх тусгай боловсрол, холбогдох үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх зөвшөөрлийг бичгээр цуцалсан тохиолдолд төрийн агентлаг нь:

1. Хүүхдийг тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээнүүдээр үргэлжлүүлэн хангахгүй байж болох хэдий ч, энэхүү үйлчилгээг зогсоохын өмнө *CFR 34-р зүйлийн 300.503* хэсэгт заасны дагуу бичгээр урьдчилж мэдэгдэнэ

2. *CFR* 34-р зүйлийн 300-р хэсгийн E дэд хэсэгт заасан журмыг (*CFR* 34-р зүйлийн 300.506-д заасан зуучлалын журам эсвэл *CFR* 34-р зүйлийн 300.507-оос 300.516-д заасан зохих журмын дагуу) тохиролцоонд хүрэх эсвэл хүүхдэд үйлчилгээ үзүүлж болох шийдвэр гаргахын тулд ашиглаж болохгүй
3. Хүүхдэд цаашид тусгай боловсрол олгох, түүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлэхгүй тул хүүхдэд *FAPE*-ийг хүртээмжтэй байлгах ёстой гэсэн шаардлагыг зөрчсөнд тооцохгүй
4. Цаашид тусгай боловсрол, холбогдох үйлчилгээг үзүүлэхийн тулд хүүхдэд зориулсан *CFR* 34-р зүйлийн 300.320 ба 300.324 хэсгийн дагуу *IEP*-ийн багийн хурлыг зарлах эсвэл *IEP*-ийг боловсруулах шаардлагагүй

CFR 34-р зүйлийн 300.9 (c)(3) зүйлд заасны дагуу эцэг эх нь хүүхдэд тусгай боловсрол, түүнтэй холбоотой үйлчилгээг үзүүлсэний дараа хүүхдийн тусгай боловсролын үйлчилгээ авах зөвшөөрлийг бичгээр цуцалсан тохиолдолд зөвшөөрөл хүчингүй болох тул төрийн агентлаг нь хүүхдийн тусгай боловсрол, холбогдох үйлчилгээ авсан тухай лавлагааг арилгахын тулд хүүхдийн боловсролын бүртгэлд өөрчлөлт оруулах шаардлагагүй болохыг анхаарна уу.

Орлогч эцэг эхийн томилгоо

Хэрэв эцэг эхийг тогтоох эсвэл олох боломжгүй бол яах вэ?

Сургуулийн дүүргүүд эцэг эхийг нь тогтоох боломжгүй, болон эцэг эхийнх нь хаана байгааг олж мэдэх боломжгүй үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийг орлон гүйцэтгэх хувь хүнийг томилох ёстой.

Хэрэв хүүхэд асран хамгаалагчгүй, орон гэргүй, бага залуу настай, төрийн халамжийн болон байгууллагын хуулийн дагуу шүүхээр бие даах чадваргүй, асрамжийн хамгаалалтад байгаа нь тогтоогдсон бөгөөд тусгай боловсролд хамрагдах гэж байгаа эсвэл аль хэдийн *IEP*-тэй бол түүнд орлогч эцэг эхийг томилж болно. (*USC* 20-р зүйлийн 1415[b][2] хэсэг; *CFR* 34-р зүйлийн 300.519 хэсэг; *EC* 56050 хэсэг; *Засгийн газрын хуулийн* 7579.5 ба 7579.6 хэсгүүд)

Ялгаварлан гадуурхалтаас ангид үнэлгээ

Тусгай боловсролын үйлчилгээ авахад миний хүүхдэд хэрхэн үнэлгээ хийх вэ?

Та хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй гэж таамаглаж байгаа бүх чиглэлээр үнэлгээ хийлгэх эрхтэй. Үнэлгээнд ашиглагдах материал, журам болон хуваарилалт нь арьс өнгөний, соёлын эсвэл бэлгийн ялгаварлан гадуурхалтгүй байх ёстой.

Үнэлгээ хийх материалаар хангах ёстой бөгөөд хэрэв хангах эсвэл удирдах огт боломжгүй л биш бол, шалгалтыг хүүхдийн төрөлх хэл дээр, харилцааных нь арга хэлбэрээр, мөн тухайн хүүхэд сурлага, хөгжил, үйл ажиллагааны хувьд юу мэддэг, юу хийж чаддаг талаар нь үнэн зөв мэдээлэл гаргаж ирэх хэлбэрээр явуулах ёстой.

Таны хүүхдийн шаардлага хангасан байдал болон FAPЕ-ийг боловсруулахад ямар ч ажиллагаа цор ганц шалгуур болж чадахгүй. (*USC 20-р зүйлийн 1414[b][1]–[3], 1412[a][6][B] хэсэг; CFR 34-р зүйлийн 300.304 хэсэг; EC 56001[j] ба 56320 хэсгүүд*)

Боловсролын бие даасан үнэлгээ

Миний хүүхдийг бие даасан шалгалтад дүүргийн зардлаар хамруулж болох уу?

Хэрэв та сургуулийн дүүргээс хийсэн үнэлгээний үр дүнтэй санал нийлэхгүй байгаа бол улсын зардлаар үнэлгээ явуулах эрхтэй хүнд хүсэлт тавьж, хүүхэддээ боловсролын бие даасан үнэлгээ хийлгүүлэх эрхтэй.

Эцэг эх нь төрийн агентлагаас гаргасан үнэлгээтэй санал нийлэхгүй байгаа тохиолдол бүрт улсын зардлаар зөвхөн нэг удаа боловсролын бие даасан үнэлгээ хийлгэх эрхтэй.

Сургуулийн дүүрэг таны боловсролын бие даасан үнэлгээ хийлгэх хүсэлтэд хариу өгөх ёстой бөгөөд боловсролын бие даасан үнэлгээг хаанаас авах тухай мэдээллээр хангах ёстой.

Хэрэв сургуулийн дүүрэг нь дүүргийн үнэлгээг зохистой гэж үзээд бие даасан үнэлгээ хийх шаардлагатай гэдэгтэй санал нийлэхгүй бол тухайн сургуулийн дүүрэг үнэлгээ зохистой хийгдсэнийг нотлохын тулд зохих журмын дагуу сонсгол явуулах хүсэлт гаргах ёстой. Хэрэв дүүргийн талд шийдэгдсэн тохиолдолд та бие

даасан үнэлгээ хийлгэх эрхтэй хэвээр байгаа ч, энэ нь улсын зардлаар биш байх юм. IEP-ийн баг бие даасан үнэлгээг харгалзан авч үзэх ёстой.

Дүүргийн үнэлгээний үйл явц нь сурагчдыг анги танхим дотор ажиглахыг зөвшөөрдөг. Хэрэв сургуулийн дүүрэг таны хүүхдийг ангид нь ажиглалт хийх үед эсвэл сургуулийн дүүрэг таны хүүхдэд ажиглалт хийх зөвшөөрөл авсан байх үед боловсролын бие даасан үнэлгээ явуулах хувь хүнд ч гэсэн таны хүүхдийг ангид ажиглах зөвшөөрөл өгөх ёстой.

Хэрэв сургуулийн дүүрэг таны хүүхдэд зориулсан сургуулийн шинэ нөхцөлийг санал болгоод, мөн боловсролын бие даасан үнэлгээ хийгдэж байгаа бол бие даасан үнэлгээ хийж буй хүнд тухайн санал болгосон шинэ нөхцөлийг эхлээд ажиглахыг зөвшөөрөх ёстой. (*USC* 20-р зүйлийн 1415[b][1] ба [d][2][A] хэсгүүд; *CFR* 34-р зүйлийн 300.502 хэсэг; *EC* 56329[b] ба [c] хэсгүүд)Сургалтын бүртгэл рүү нэвтрэх эрх

Би хүүхдийнхээ сургалтын явцын бүртгэлийгхянаж болох уу?

Та хүүхдийнхээ IEP-ийн хурлын өмнө эсвэл зохих шатны сонсголын өмнө хүүхдийнхээ сургалтын бүхий л бүртгэлийг ямар ч саадгүйгээр хянаж, шалгах эрхтэй. Сургуулийн дүүрэг танд бичлэг, хуулбарт нэвтрэх эрх олгох ёстой бөгөөд, хэрэв хүсэлт гаргасан бол, амаар эсвэл бичгээр хүсэлт гаргаснаас хойш **ажлын** таван өдрийн дотор эрх олгоно. (*EC* 49060, 56043[n], 56501[b][3] ба 56504 хэсгүүд)

Маргаан шийдвэрлэх

Зохих шатны сонсгол

Зохих шатны сонсголыг хэзээ хийдэг вэ?

Та хүүхдийнхээ тодорхойлолт, үнэлгээ, боловсролын хуваарилалт эсвэл FAPЕ-ээр хангахтай холбоотой асуудлаар зохих шатны шударга сонсгол явуулахыг шаардах эрхтэй. Зохих шатны сонсгол явуулах хүсэлтийг зохих шатны гомдол гаргах болсон үндэс суурийг нь тавьсан сэжигтэй үйл ажиллагааны тухай олж мэдсэн эсвэл мэдэх ёстой байсан өдрөөс хойш хоёр жилийн дотор гаргах ёстой. (*USC* 20-р зүйлийн 1415[b][6] хэсэг; *CFR* 34-р зүйлийн 300.507 хэсэг; *EC* 56501 ба 56505[l] хэсгүүд)

Эвлэрүүлэн зуучлах болон маргаан шийдвэрлэх өөр арга

Би эвлэрүүлэн зуучлах эсвэл маргаан шийдвэрлэх өөр арга хүсч болох уу?

Эвлэрүүлэн зуучлах хүсэлтийг зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргахын өмнө эсвэл дараа гаргах боломжтой.

Та сургуулийн дүүргээс маргааныг эвлэрүүлэн зуучлах замаар эсвэл маргаан шийдвэрлэх өөр замаар (ADR) шийдвэрлэх хүсэлт тавьж болох бөгөөд энэ нь зохих шатны сонсголыг бодвол маргаан багатай байдаг. ADR болон эвлэрүүлэн зуучлал нь маргааныг шийдвэрлэх сайн дурын аргууд бөгөөд энэ нь таны зохих шатны сонсгол явуулах эрхийг саатуулахад ашиглагдах боломжгүй.

Сонсголын өмнөх эвлэрүүлэн зуучлах хурал гэж юу вэ?

Та зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргахын өмнө эвлэрүүлэн зуучлах замаар шийдэлд хүрэхийг хүсч болно. Хурал нь хүүхдийн тодорхойлолт, үнэлгээ, боловсролын хуваарилалттай эсвэл FARE-тэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор маргаангүй байдлаар явагдах албан бус ажиллагаа юм.

Сонсголын өмнөх эвлэрүүлэн зуучлах хурал дээр эцэг эх эсвэл сургуулийн дүүрэг нь өмгөөлөгчийн эрхтэй бус төлөөлөгчийн хамт байж, зөвлөгөө авч болох ба, хурлын өмнө эсвэл дараа өмгөөлөгчтэй зөвлөлдөж болно. Гэсэн хэдий ч сонсголын өмнөх эвлэрүүлэн зуучлах хурал хийх хүсэлт гаргах эсвэл оролцох нь зохих шатны сонсгол явуулах хүсэлтийг гаргах урьдчилсан нөхцөл биш юм.

Сонсголын өмнөх эвлэрүүлэн зуучлах хурал хийх бүх хүсэлтийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх газрын (ОАН) даргад гаргана. ОАН-ын даргад сонсголын өмнөх эвлэрүүлэн зуучлах хурал зохион байгуулах хүсэлтийг бичгээр гаргаж өгсөн тал хүсэлтийн хуулбарыг эвлэрүүлэн зуучлах хуралд оролцох нөгөө талд нэгэн зэрэг өгнө.

Сонсголын өмнөх эвлэрүүлэн зуучлах хурлын хугацааг ОАН-ын дарга эвлэрүүлэн зуучлалын хүсэлт хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор товлох бөгөөд хоёр тал хугацааг сунгахаар тохиролцоогүй л бол эвлэрүүлэн зуучлалын хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дуусгавар болгоно. Хэрэв шийдвэрт хүрсэн тохиолдолд, талууд тус шийдвэрийг тусгасан хууль ёсны дагуу хүчин төгөлдөр гэрээг бичгээр үйлдэнэ. Эвлэрүүлэн зуучлалын явцад хийгдэх бүх хэлэлцүүлэг нууцлалын зэрэгтэй байна. Сонсголын өмнөх бүх эвлэрүүлэн зуучлах хурлыг цаг тухайд нь товлож, талуудад тохиромжтой цаг хугацаа болон газарт зохион байгуулна. Хэрэв асуудал бүх талуудын сэтгэлд нийцсэн байдлаар шийдэгдэж

T21-822, Хамгааллын журмын тухай мэдэгдэл, Англи хэл, Arial фонт
Калифорнийн Боловсролын Газар
Хуудас 10/23

чадаагүй бол эвлэрүүлэн зуучлах хурал хийх хүсэлтийг гаргасан тал зохих шатны сонгогч явуулах хүсэлтээ гаргах эрхтэй. (EC 56500.3 ба 56503 хэсгүүд)

Зохих журмын эрх

Би ямар зохих журмын эрхтэй вэ?

Та дараах эрхүүдийг эдэлнэ:

1. Тусгай боловсрол болон захиргааны сонсголыг зохицуулах хуулийн талаар мэдлэгтэй хүний өмнө төрийн түвшинд шударга ба ялгаваргүй захиргааны сонсголыг явуулах (USC 20-р зүйлийн 1415[f][1][A], ба 1415[f][3][A]-[D] хэсгүүд; CFR 34-р зүйлийн 300.511 хэсэг; EC 56501[b][4] хэсэг)
2. Өмгөөлөгч ба/эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар мэдлэгтэй хувь хүмүүстэй хамт оролцох, тэднээс зөвлөгөө авах (EC 56505 [e][1] хэсэг)
3. Нотлох баримт, аман болон бичгэн тайлбаруудыг танилцуулах (EC 56505[e][2] хэсэг)
4. Сөргөлдөх , хөндлөнгөөс шалгах мөн гэрчүүдийг байлцуулахыг шаардах (EC 56505[e][3] хэсэг)
5. Сонсголын баримт болон шийдвэрийн дүгнэлтийг бичгээр эсвэл эцэг эхийн сонголтоор цахим протоколоор хүлээн авах (EC 56505[e][4] хэсэг)
6. Сонсголд хүүхдээ оролцуулах (EC 56501[c][1] хэсэг)
7. Сонсголыг олон нийтэд нээлттэй эсвэл хаалттай явуулах (EC 56501[c][2] хэсэг)
8. Сонсгол болохоос өмнө ажлын таван (5) өдрийн дотор тухайн өдрийг хүртэл хийсэн үнэлгээ, зөвлөмж, гэрчүүдийн жагсаалт болон тэдний мэдүүлгийн ерөнхий цар хүрээ зэргийг багтаасан бүх баримт бичгийн хуулбарыг хүлээн авах (EC 56505[e][7] ба 56043[v] хэсгүүд)
9. Сонсгол эхлэхээс календарийн арваас (10) доошгүй өдрийн өмнө бусад талуудын зүгээс асуудал, мөн тэдний санал болгож буй шийдлүүдийн талаар мэдээлэл авах (EC 56505[e][6] хэсэг)
10. Орчуулагчтай байх (Калифорний зохицуулалтын тухай хууль, Бүлэг 5 (5 CCR) 3082[d] хэсэг)
11. Сонсголын хугацааг сунгах хүсэлт гаргах (EC 56505[f][3] хэсэг)

12. Зохих шатны сонсголын аль ч үед эвлэрүүлэн зуучлах хурал хийх (*EC 56501[b][2]* хэсэг), болон
13. Сонсгол болохоос дор хаяж 10 хоногийн өмнө эсрэг тал өмгөөлөгчөөр төлөөлүүлэх гэж байгаа тухай мэдэгдлийг хүлээн авах (*EC 56507[a]*) хэсэг. (*USC 20-р зүйлийн 1415[e]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.506, 300.508, 300.512 ба 300.515* хэсгүүд)

Зохих шатны гомдлыг бичгээр гаргах

Би хэрхэн зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргах вэ?

Та зохих шатны сонсгол явуулах хүсэлтээ бичгээр гаргах шаардлагатай. Та эсвэл таны төлөөлөгч хүсэлтэндээ дараах мэдээллийг оруулах хэрэгтэй:

1. Хүүхдийн нэр
2. Хүүхдийн оршин суугаа хаяг
3. Хүүхдийн сурч байгаа сургуулийн нэр
4. Орон гэргүй хүүхдийн хувьд, хүүхэдтэй холбоо барих боломжтой хаяг болон хүүхдийн сурч байгаа сургуулийн нэр, болон
5. Асуудлын мөн чанарын тайлбар, асуудал(ууд)-тай холбоотой баримтууд болон асуудлыг шийдвэрлэх санал зэрэг зүйлс багтана

Холбооны болон мужийн хууль тогтоомжид зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргасан талууд аль аль нь бичгээр гаргасан хүсэлтийн хуулбараа нөгөө талдаа өгөх ёстой. (*USC 20-р зүйлийн 1415[b][7]* ба *1415[c][2]* хэсгүүд; *CFR 34-р зүйлийн 300.508* хэсэг; *EC 56502[c][1]* хэсэг)

Зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргахын өмнө эцэг эх болон зохих шатны сонсгол явуулах хүсэлтэд тодорхойлсон баримтын талаар тодорхой мэдлэгтэй IEP-ийн багийн гишүүд хоорондын хурал буюу шийдвэрлэх хурлыг зарлан хуралдуулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжийг сургуулийн дүүрэгт олгоно. (*USC 20-р зүйлийн 1415[f][1][B]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.510* хэсэг)

Шийдвэрлэх хуралд юу багтдаг вэ?

Зохих шатны сонсгол явуулах эцэг эхийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шийдвэрлэх хурлыг зарлан хуралдуулна. Хуралд сургуулийн дүүргийн шийдвэр гаргах эрх бүхий төлөөлөгчийг оролцуулах бөгөөд эцэг эх

өмгөөлөгчийн хамт ирэхээс нааш сургуулийн дүүргийн өмгөөлөгчийг оролцуулахгүй. Хүүхдийн эцэг эх нь зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргахад хүргэсэн үндсэн асуудал болон баримтуудыг хэлэлцэж болно.

Хэрэв эцэг эх болон сургуулийн дүүрэг хурлаас татгалзахыг бичгээр зөвшөөрсөн тохиолдолд шийдвэрлэх хурал хийх шаардлагагүй. Сургуулийн дүүрэг нь зохих шатны сонсголын асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлээгүй бол зохих шатны сонсголыг хийж болно. Хэрэв шийдвэрт хүрсэн бол талууд хуулийн дагуу хүчин төгөлдөр гэрээ байгуулна. (*USC 20-р зүйлийн 1415[f][1][B]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.510* хэсэг)

Үйл ажиллагааны явцад миний хүүхдийн хуваарилалт өөрчлөгдөх үү?

Та болон сургуулийн дүүрэг өөр зохицуулалт хийхээр тохиролцоогүй л бол аливаа захиргааны болон хуулийн ажиллагаанд оролцож буй хүүхэд одоогийн боловсролын хуваарилалтандаа хэвээр үлдэх ёстой. Хэрэв та хүүхдээ улсын сургуульд элсүүлэх хүсэлт гаргаж байгаа бол бүх үйл ажиллагаа бүрэн дуусах хүртэл таны зөвшөөрлийн дагуу таны хүүхдийг улсын сургуулийн хөтөлбөрт хамруулах болно. (*USC 20-р зүйлийн 1415[j]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.518* хэсэг; *EC 56505[d]* хэсэг)

Шийдвэрийг давж заалдаж болох уу?

Сонсголын шийдвэр нь эцсийн шийдвэр байх бөгөөд хоёр тал заавал биелүүлэх үүрэгтэй. Талуудын аль аль нь эцсийн шийдвэр гарснаас хойш 90 хоногийн дотор мужийн эсвэл холбооны шүүхэд иргэний нэхэмжлэл гарган, сонсголын шийдвэрийг давж заалдах боломжтой. (*USC 20-р зүйлийн 1415[i][2]* ба *[3][A]*, ба *1415[i]* хэсгүүд; *CFR 34-р зүйлийн 300.516* хэсэг; *EC 56505[h]* ба *[k]* хэсгүүд, *EC 56043[w]* хэсэг)

Миний өмгөөлөгчийн төлбөрийг хэн төлөх вэ?

Зохих шатны сонсголтой холбоотой аливаа үйлдэл эсвэл үйл ажиллагаанд хэрэв та сонсголын давуу эрхтэй тал бол шүүх өөрийн сонголтоор таныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн хувьд танаас гарах зардлын нэг хэсэг болох өмгөөлөгчийн зохих төлбөрийг өгч болно. Захиргааны сонсголын үр дүнд тулгуурлаж хийсэн талуудын тохиролцоогоор мөн өмгөөллийн зохих хөлсийг төлж болно. (*USC 20-р зүйлийн 1415[i][3][B]–[G]* хэсгүүд; *CFR 34-р зүйлийн 300.517* хэсэг; *EC 56507[b]* хэсэг)

Дараах нөхцлүүдийн аль нэг нь давамгайлсан тохиолдолд төлбөрийг бууруулж болно:

1. Шүүх таныг маргааны эцсийн шийдвэрийг үндэслэлгүйгээр хоцроосон гэж үзвэл
2. Өмгөөлөгчдийн цагийн хөлс нь ур чадвар, нэр хүнд, туршлагаараа ижил төстэй бусад өмгөөлөгчдийн үйлчилгээний хөлснөөс давсан ханштай бол
3. Хэтэрсэн их цаг хугацаа зарцуулсан болон хуулийн үйлчилгээ үзүүлсэн бол, эсвэл
4. Таны өмгөөлөгч зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргах мэдэгдэлд сургуулийн дүүргийг зохих мэдээллээр хангаагүй бол.

Гэсэн хэдий ч, шүүх тухайн муж эсвэл сургуулийн дүүргийг үйлдэл эсвэл хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шийдвэрийг үндэслэлгүйгээр хойшлуулсан эсвэл хуулийн энэ хэсгийг зөрчсөн гэж үзвэл өмгөөлөгчийн төлбөрийг бууруулахгүй. (USC 20-р зүйлийн 1415[i][3][B]-[G] хэсгүүд; CFR 34-р зүйлийн 300.517 хэсэг)

IEP-ийн багийн хурлыг зохих шатны сонсголын үйл ажиллагаа эсвэл хуулийн ажиллагааны үр дүнд зарлан хуралдуулаагүй бол IEP-ийн багийн аливаа хуралтай холбоотой өмгөөлөгчийн төлбөрийг олгохгүй байж болно. Хэрэв та сонсгол эхлэхээс 10 хоногийн өмнө дүүргийн/төрийн байгууллагаас гаргасан үндэслэл бүхий тохиролцооны саналаас татгалзаж, сонсголын шийдвэр нь тохиролцооны саналаас таатай бус нөхцөлд өмгөөлөгчийн төлбөрийг олгохоос татгалзаж болно. (USC 20-р зүйлийн 1415[i][3][B]-[G] хэсгүүд; CFR 34-р зүйлийн 300.517 хэсэг)

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах, эвлэрүүлэн зуучлах эсвэл зохих шатны сонсгол явуулах хүсэлт гаргах бол дараах хаягаар холбогдоно уу:

[Захиргааны хэргийн сонсголын газар
Анхаарах: Тусгай боловсролын хэлтэс
2349 Гейтвей Оакс Драйв, 200 тоот
Сакраменто, Калифорни муж 95833-4231
Утасны дугаар: 916-263-0880
Факс: 916-263-0890]

Мөн ОАН-тай Аюулгүй цахим файл дамжуулах (SFT) системийг ашиглан имэйлээр холбогдож болно. SFT-ыг ОАН-ын вебсайтаас олох боломжтой
<https://www.applications.dgs.ca.gov/OAH/oahSFTWeb>

Сургуулийн эмх журам ба хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хуваарилах ажиллагаа

Сургуулийн эмх журам ба түр хугацааны боловсролын өөр орчин нөхцөл

Миний хүүхдийг түдгэлзүүлэх эсвэл хасах боломжтой юу?

Сургуулийн боловсон хүчин нь сурагчийн дүрэм зөрчсөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хуваарилтад өөрчлөлт оруулах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо тохиолдол тус бүрээс хамаараад ямар нэг онцгой нөхцөл байдлыг харгалзан үзэж болно:

- Тохирох түр хугацааны боловсролын орчин, өөр нөхцөл эсвэл дараалласан хичээлийн 10 өдрөөс илүүгүй хугацаагаар түдгэлзүүлэх
- Ёс бус үйлдэл гаргасан тохиолдолд тухайн хичээлийн жилд дараалсан 10-аас илүүгүй хичээлийн өдрөөр сургуулиас хасах

10-аас илүү өдөр хасалт хийвэл дараа нь яах вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг түүний одоо сурч байгаа сургуулиас нь тухайн хичээлийн жилд хичээлийн 10 өдөр сургуулиас хассаны дараа төрийн байгууллага нь тус хүүхдийг үргэлжлүүлэн ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хамруулах ёстой бөгөөд IEP-т заасан зорилгод хүрэхэд ахиц дэвшил гаргах боломжоор хангах ёстой. Түүнчлэн, хүүхдэд харилцааны зөрчлийг нь дахин давтуулалгүй арилгах зорилготой зохих ёсны харилцааны функционал үнэлгээ, харилцаа бүхий оролцооны үйлчилгээ, өөрчлөлт зэргийг хийнэ.

Хэрэв хүүхэд ийм байдалтай 10 хоногоос хэтэрвэл хүүхдийн буруутай үйлдлийг хөгжлийн бэрхшээлээс үүдэн гарсан эсэхийг тодорхойлохоор IEP-ийн багийн хурлыг хуралдуулна. IEP-ийн энэхүү багийн хурлыг нэн даруй, хэрэв боломжтой бол сургуулийн дүүрэг ийм төрлийн сахилгын арга хэмжээ авах шийдвэр гаргаснаас хойш 10 хоногийн дотор хуралдуулах ёстой.

Эцэг эхийн хувьд таныг IEP-ийн багийн гишүүнээр оролцохыг урина. Сургуулийн дүүрэг зүй бус үйлдлийг арилгахын тулд үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулах, мөн хэрэв таны хүүхдэд зан харилцааны хөндлөнгийн төлөвлөгөө байдаг бол шаардлагатай хэлбэрээр төлөвлөгөөг хянаж, өөрчлөлт оруулах шаардлага үүсч болно.

IEP-ийн баг буруутай үйлдлийг хөгжлийн бэрхшээлээс шалтгаалаагүй гэж тогтоовол яах вэ?

Хэрэв IEP-ийн баг энэхүү зүй бус үйлдлийг хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрэл байгаагүй гэж дүгнэвэл, сургуулийн дүүрэг нь хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн адилаар сургуулиас хөөх зэрэг сахилгын арга хэмжээ авч болно. (*USC 20-р зүйлийн 1415[k][1]* ба *[7]* хэсгүүд; *CFR 34-р зүйлийн 300.530* хэсэг)

Хэрэв та IEP-ийн багийн шийдвэртэй санал нийлэхгүй байгаа тохиолдолд зохих шатны түргэвчилсэн сонсгол явуулах хүсэлт гаргаж болох ба хүсэлт гаргасан өдрөөс хойш хичээлийн 20 хоногийн дотор сонсголыг хийх ёстой. (*USC 20-р зүйлийн 1415[k][2]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.531[c]* хэсэг)

Сургуулийн дүүрэг ямар ч орчин нөхцлөөс үл хамааран таны хүүхдийг FAPE-ээр үргэлжлүүлэн хангах ёстой. Боловсролын өөр нөхцөл нь цаашид хүүхдэд ерөнхий сургалтын хөтөлбөрт үргэлжлүүлэн оролцох боломжийг олгож, IEP-т дэлгэрэнгүй тусгасан үйлчилгээ, өөрчлөлтүүдийг үргэлжлүүлэх боломжоор хангах ёстой. (*CFR 34-р зүйлийн 300.530* хэсэг; *EC 48915.5[b]* хэсэг)

Хувийн сургуульд явдаг хүүхдүүд

Эцэг эх нь хувийн сургуульд өгсөн сурагчид төрөөс санхүүждэг тусгай боловсролын хөтөлбөрт хамрагдаж болох уу?

Эцэг эх нь хувийн сургуульд элсүүлэн суралцаж буй хүүхдүүд төрөөс санхүүжилттэй тусгай боловсролын хөтөлбөрт хамрагдаж болно. Сургуулийн дүүрэг нь хувийн сургуулийн сурагчидад санал болгох үйлчилгээнүүдийг тодорхой болгохын тулд хувийн сургууль ба эцэг эхчүүдтэй зөвлөлдөх ёстой. Хэдийгээр сургуулийн дүүргүүд нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчидад FAPE санал болгох тодорхой үүрэг хүлээдэг хэдий ч, эцэг эх нь хувийн сургуульд оруулсан бол тэдгээр хүүхдүүд FAPE-ээс хангах үүрэгтэй тусгай боловсрол, холбогдох үйлчилгээг авах эрхгүй эсвэл бүрэн авах эрхгүй болдог. (*USC 20-р зүйлийн 1415[a][10][A]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.137* ба *300.138* хэсгүүд; *EC 56173* хэсэг)

Хэрэв тусгай хэрэгцээтэй хувь хүний эцэг эх өмнө нь сургуулийн дүүргийн тусгай боловсрол, холбогдох үйлчилгээг авч байгаад, дараа нь хүүхдээ орон нутгийн боловсролын агентлагийн зөвшөөрөл, томилгоогүйгээр хувийн бага , дунд сургуульд элсүүлсэн тохиолдолд, хэрэв дүүргээс FAPE-ээр хангах боломжтой болгосон бол сургуулийн дүүрэг тусгай боловсролоор хангах шаардлагагүй. Шүүх эсвэл зохих шатны сонсголын ажилтан нь хүүхдийг хувийн бага , дунд сургуульд элсэхээс өмнө сургуулийн дүүрэг FAPE-ээр хангах нөхцлийг бүрдүүлээгүй тухай олж мэдвэл, шүүх эсвэл зохих шатны сонсголын ажилтан сургуулийн дүүргийг эцэг эх, асран хамгаалагчид нь тусгай боловсрол ба хувийн сургуулийн зардлыг нөхөн

T21-822, Хамгааллын журмын тухай мэдэгдэл, Англи хэл, Arial фонт
Калифорнийн Боловсролын Газар
Хуудас 16/23

олгохыг шаардаж болно. (*USC 20-р зүйлийн 1412[a][10][C]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.148* хэсэг; *EC 56175* хэсэг)

Нөхөн төлбөрийг ямар үед бууруулах эсвэл түдгэлзүүлэх боломжтой вэ?

Хэрэв таны хүүхдийг улсын сургуулиас хасахын өмнө сургуулийн дүүргээс хүүхдээ үнэлгээнд оруулах мэдэгдэл ирүүлэхэд бэлэн байлгаж, оруулаагүй бол шүүх эсвэл сонсголын ажилтан нөхөн төлбөрийг бууруулах эсвэл түдгэлзүүлж болно. Мөн та сургуулийн дүүргээс санал болгосон тусгай боловсролын хуваарилалтаас татгалзаж байгаагаа сургуулийн дүүрэгт мэдэгдээгүй, тэр дундаа хүүхдээ улсын зардлаар хувийн сургуульд оруулах санаатай байгаагаа илэрхийлээгүй тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзаж болно.

Сургуулийн дүүрэгт та мэдэгдлээ дараах байдлаар өгөх ёстой:

- Хүүхдээ улсын сургуулиас гаргахын өмнө оролцсон хамгийн сүүлийн IEP-ийн багийн хурал дээр, эсвэл
- Хүүхдээ улсын сургуулиас гаргахын өмнө дор хаяж ажлын 10 хоногийн өмнө (баяр ёслолын өдрүүдийг оролцуулаад) сургуулийн дүүрэгт бичгээр мэдэгдэх. (*USC 20-р зүйлийн 1412[a][10][C]* хэсэг; *CFR 34-р зүйлийн 300.148* хэсэг; *EC 56176* хэсэг)

Нөхөн төлбөрийг ямар үед бууруулахгүй, түдгэлзүүлэхгүй байж болох вэ?

Хэрэв та дараах шалтгааны улмаас сургуулийн дүүрэгт бичгээр мэдэгдэл гаргаагүй бол шүүх эсвэл сонсголын ажилтан таны нөхөн төлбөрийг бууруулах эсвэл түдгэлзүүлэх ёсгүй:

- Мэдэгдэл илгээхэд сургууль танд саад болсон
- Та энэхүү Хамгааллын журмын тухай мэдэгдлийн хуулбарыг хүлээн аваагүй эсвэл дүүрэгт мэдэгдэх шаардлагатай талаар өөр ямар нэгэн байдлаар мэдээгүй
- Мэдэгдэл илгээх нь таны хүүхдийн бие махбодид гэмтэл учруулах магадлалтай байсан
- Бичиг үсэг мэдэхгүй, англи хэл дээр бичиж чадахгүй зэрэг байдал нь танд мэдэгдэл илгээхэд саад болсон, эсвэл
- Мэдэгдэл илгээх нь таны хүүхдэд сэтгэл санааны ноцтой хохирол учруулах магадлалтай байсан

T21-822, Хамгааллын журмын тухай мэдэгдэл, Англи хэл, Arial фонт
Калифорнийн Боловсролын Газар
Хуудас 17/23

(USC 20-р зүйлийн 1412[a] [10] [C] хэсэг; CFR 34-р зүйлийн 300.148 хэсэг; EC 56177 хэсэг)

Мужид гомдол гаргах үйл явц

Дүрэм зөрчсөн тухай гомдлыг ямар үед гаргаж болох вэ?

Хэрэв та сургуулийн дүүргийг холбооны эсвэл мужийн тусгай боловсролын хууль эсвэл зохицуулалтыг зөрчсөн гэж үзэж байвал дүрэм зөрчсөн тухай гомдол гаргаж болно. Таны бичгээр гаргасан гомдолд холбооны болон мужийн тусгай боловсролын хуулийг зөрчсөн гэж үзэх доод тал нь нэг зөрчлийг зааж өгөх ёстой. Зөрчил нь CDE-г гомдол хүлээн авахаас нэг жилээс илүүгүй хугацааны өмнө гарсан байх ёстой. Гомдол гаргахдаа та дүрэм зөрчсөн гомдлыг CDE-д гаргахын хамт сургуулийн дүүрэг рүү мөн гомдлын хуулбарыг илгээх ёстой. (CFR 34-р зүйлийн 300.151–153 хэсэг; 5 CCR 4600 хэсэг)

Холбооны болон мужийн тусгай боловсролын хууль тогтоомжийг зөрчсөн тухай гомдлыг дараах хаягаар илгээх боломжтой:

[Калифорнийн боловсролын газар
Тусгай боловсролын хэлтэс
Гомдол хүлээн авах хэсэг
1430 Н Гудамж, 2401 тоот
Сакраменто, Калифорни муж 95814]

Мөн гомдлоо spceducation@cde.ca.gov хаягаар илгээж болно

Холбооны болон мужийн тусгай боловсролын хууль, зохицуулалтад тусгагдаагүй асуудалтай холбоотой гомдол гаргах бол дүүргийнхээ гомдол гаргах журамтай танилцаарай.

Маргаан шийдвэрлэлт, тухайлбал хэрхэн гомдол гаргах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл CDE, Тусгай боловсролын хэлтэс, Гомдол хүлээн авах хэсэгтэй 800-926-0648 дугаарын утсаар; 916-327-3704 факсаар холбогдох; эсвэл CDE, Тусгай боловсролын веб хуудас <https://www.cde.ca.gov/sp/se/index.asp> хаягаар зочилно уу.

Сенат Билл 511, Гэр бүлийг чадавхижуулах төвүүд

Оршил

2001 оны Хууль эрхийн актын 690-р бүлгийг (Сенат Билл 511, Альперт) зөвшөөрснөөр Гэр бүлийг чадавхижуулах төвүүд (FECs) 2001 онд байгуулагдаж, *Боловсролын тухай хуулиар (EC) 56400-56415* хуульчилсан. FECs нь 3-22 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлүүдэд үйлчилгээ үзүүлдэг. Хууль тогтоох байгууллагын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлүүдэд үнэн зөв мэдээлэл, тусгай сургалт болон үе тэнгийнхэний дэмжлэгийг авах боломжоор хангахад оршино.

FEC холбоо барих болон үйлчилгээний мэдээлэл

Байгууллага	Үйлчлэх мужууд	Вебсайт
Сан Матео каунти дахь Ability Path's гэр бүлийн тусламжийн төв	Сан Матео	https://www.smcfrc.org/
Alpha Гэр бүлийн тусламжийн төв	Санта Барбара	https://alphasb.org/
Ховор гэр бүлийн тусламжийн төв (EFRC)	Империа, Сан Диего	https://efrconline.org/
Хязгаарлалтгүй онцгой эцэг эх (EPU)	Фресно, Кингс	https://www.epuchildren.org/
Хязгаарлалтгүй онцгой эцэг эх (EPU)	Мадера	https://www.epuchildren.org/
Гэр бүл дээр төвлөрөх тусламжийн болон чадавхижуулах төв	Хойд Лос Анжелес (Сан Фернандо, Санта Кларита, Антелоп валлей)	https://csun.edu/family-focus-resource-center
Гэр бүлийн тусламжийн навигаторууд	Аламеда	https://familyresourcenavigators.org/
Гэр бүлийн SOUP	Колуса, Саттер, Юуба	http://www.familysoup.org/
Н.Е.А.Р.Т.С.	Керн	http://www.heartsfrc.org/

Гэр бүлийн харилцааны тусламжийн болон чадавхижуулах төв		
Heluna Health / Зүүн Лос Анжелесийн гэр бүлийн тусламжийн төв	Лос Анжелес (Альхамбра, Аркадиа, Бойл Хэйтс, Сити Террейс, Коммерс, Зүүн Лос Анжелес, Зүүн Пасадена, Эль Серено, Бүргэдийн хад/Хайланд парк, Ла Хабра Хэйтс, Ла Мирада, Линкольн Хэйтс, Монтебелло, Монтерей парк, Маунт Вашингтон, Пико Ривера, Роузмед, Сан Габриел, Сан Марино, Өмнөд Пасадена, Санта Фе Спрингс, Темпл сити, Вайтиер)	https://www.helunahealth.org/partners/eastern-los-angeles-regional-family-resource-center/
Matrix Эцэг эхийн харилцаа холбоо болон тусламжийн төв	Напа, Солано, Сонома	https://www.matrixparents.org/
Matrix Эцэг эхчүүдийн холбоо	Марин	https://www.matrixparents.org/
Parents Helping Parents, Inc. (Эцэг эхчүүд бие биедээ туслах байгууллага)	Санта Клара	https://www.php.com/
Parents Helping Parents San Luis Obispo (Эцэг эхчүүд бие биедээ туслах байгууллага, Сан Луи Обиспо)	Сан Луи Обиспо	http://www.phpso.org/
The Parents' Place Гэр бүлийн тусламжийн төв	Лос Анжелес (Сан Габриелын валлей, Помона)	http://www.parentsplacefrc.com/
Plumas Rural Services, Inc.	Лассен, Модок, Плумас, Сиерра	https://www.plumasruralservices.org/
Хойд Калифорнийн Ровелл гэр бүлийг	Бутте, Гленн, Шаста, Сискиюу, Техама, Тринити	https://rfenc.org/Home/

чадавхижуулах төв (RFENC)		
Лос Анжелесийн өмнөд бүсийн төв (МакКлэни гэр бүлийн тусламжийн төв)	Лос Анжелес (Өмнөд Лос Анжелес дотроо: Ваттс, Леймерт парк , Флоренс/Файрстоун, Вест Адамс, Белл, Велл Гарденс, Комптон, Кудахи, Дауни, Хантингтон парк , Линвуд, Мэйвуд, Вернон, Өмнөд Гейт, Хойд Карсон, Гардена, Парамоунт)	https://sclarc.org/
Тусгай хүүхдүүдийн холбоо	Монтерей	https://specialkidsconnect.org/
Тусгай эцэг эхчүүдийн мэдээллийн сүлжээ (SPIN)	Сан Бенито, Санта Круз	https://www.spinca.org/
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэр бүлийг дэмжих төв	Сан Франциско	https://www.supportforfamilies.org/
Тусгай хүүхдүүдийн өмгөөлөгчдийн баг, Inc. (TASK)	Оранж	https://taskca.org/
Тусгай хүүхдүүдийн өмгөөлөгчдийн баг, Inc. (TASK)	Лос Анжелес (Артезиа, Авалон, Беллфлауэр, Карсон, Серритос, Харбор сити, Харбор гейтвэй, Хавайн гарденс, Хермоса далайн эрэг, Лейквуд, Ломита, Лонг далайн эрэг, Манхэттэн далайн эрэг, Норволк, Палос Вердес Истэйтс, Вердес Истэйтс, Ранчо, Палос Вердес, Роллинг Хиллс, Сан Педро, Сигнал Хилл, Торранс, Вилмингтон)	https://taskca.org/

T21-822, Хамгааллын журмын тухай мэдэгдэл, Англи хэл, Arial фонт
Калифорнийн Боловсролын Газар
Хуудас 21/23

Тусгай хүүхдүүдийн өмгөөлөгчдийн баг, Inc. (TASK)	Лос Анжелес (Сигнал Хилл, Лонг далайн эрэг , Каталина арал)	https://taskca.org/
Тусгай хүүхдүүдийн өмгөөлөгчдийн баг, Inc. (TASK)	Лос Анжелес (Лейквуд, Зүүн Лейквуд, Хавайн гарденс, Беллфлауэр, Норволк/Литтл Лейк, Артезиа, Серритос)	https://taskca.org/
Warmline Гэр бүлийн тусламжийн төв	Альпин, Эль Дорадо, Невада, Плейсер, Сакраменто, Ёоло	http://www.warmlinefrc.org/
Westside Гэр бүлийн тусламжийн төв	Баруун Лос Анжелес	http://wfrec.org/

Энэхүү мэдэгдэлд ашигласан товчлолын тайлбар толь

ADR: Alternative Dispute Resolution /Маргаан шийдвэрлэх өөр арга/

CFR: Code of Federal Regulations /Холбооны улсын хууль тогтоомж/

EC: California Education Code /Калифорний боловсролын тухай хууль тогтоомж/

FAPE: Free Appropriate Public Education /Улсын зохих ёсны үнэ төлбөргүй сургалт/

FEC: Family Empowerment Center on Disability /Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүлийг чадавхижуулах төвүүд/

IDEA: Individuals with Disabilities Education Act /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хууль/

IEP: Individualized Education Program /Ганцаарчилсан боловсролын хөтөлбөр/

PTIC: Parent Training and Information Center /Эцэг эхийн сургалт болон мэдээллийн төвүүд/

ОАН: Office of Administrative Hearings /Захиргааны хэргийн сонсголын газар/

SELPA: Special Education Local Plan Area /Тусгай боловсролын орон нутгийн төлөвлөлтийн бүс/

USC: United States Code /АНУ-ын хууль тогтоомж/